

БАТЛАВ.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.АМГАЛАНБААТАР**

**МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

1.1.Хууль зүйн зохицуулалтын үндэслэл, хэрэгцээ

Монгол улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.”, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхтэй;” гэж тус тус тунхагласан. 1992 онд Монгол улсын Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол улсын төрөөс хүний эрхийг хамгаалах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай¹, Эрүүл мэндийн тухай хууль², Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль³, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал⁴ зэрэг эрх зүйн бодлогын баримт бичгүүдийг баталсан байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр баталж, хэрэгжүүлсэн боловч

- “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис”-ын хууль бус эргэлт, Шүүхээр шийдвэрлэгдэж буй хэргийн тоо эрс нэмэгдэж, шүүхээс гэм буруутайд тооцогдсон хүний нас залуужиж буй нь Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 дэх хэсгийн 3.4.8-д заасан “хүн ам, удмын сангийн аюулгүй байдал”-д сөрөг нөлөө үзүүлэхэд хүрч байгаа тул хуулийн зохицуулалтын хувьд шинэчлэх;

-хуулийн агуулгын хувьд мөн хуулийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилтыг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн нь:

-“мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис”-ыг ижил эд зүйл мэтээр мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.2-т томъёолсон;

-“мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль ёсны эргэлт, хуулиар хориглосон эргэлт” гэдгийг тус тусд нь ялгамжтайгаар тус тус томъёолоогүй нь нийгмийн хөгжлийн өнөөгийн харилцаанд бүрнээ нийцэхгүй буюу Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн 25.1.4-д заасан “тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002 он, №46

² Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2011 он, №21

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002 он, №3

⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2010 он, №36

ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон.” Хууль зүйн үндэслэл, хэрэгцээтэй гэж үзсэн болно.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис нь:

-Монгол улсын хууль, олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн буюу хууль ёсны,

-Монгол улсын хууль, олон улсын гэрээгээр хориглосон буюу “хууль бус” 2 төрлийн эргэлттэй байгаа тул хуулийн зохицуулах зүйл, агуулгад зарчмын өөрчлөлтүүдийг тусгаж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.3-т заасан “хуулийн шинэчилсэн найруулга” хэлбэрээр төслийг боловсрууллаа.

1.2.Практик хэрэгцээ

Хүний эрхийг хамгаалах нь дэлхий нийтийн анхаарлын төвд байх нийтлэг асуудал мөн боловч аливаа улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал нь иргэдийн удмын сан, үндэсний соёл, өв уламжлалын дархлааг хадгалах, өвлүүлэх явдлаар баталгааждаг тул тусгаар тогтносон улс бүрийн төрийн бодлогын нэн тэргүүнд байсаар ирсэн онцгой ач холбогдол бүхий асуудал юм.

Монголын Хуульчдын Холбооноос 2024 онд хийж гүйцэтгэсэн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн талаарх судалгаа”-г сүүлийн 10 жилийн байдлаар судалж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой асуудал Монгол хүний удмын сан, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхүйц хэмжээнд хүрснийг онцлон тэмдэглэж дараах дүгнэлтийг хийсэн байна. Үүнд:

1.2002 оны Эрүүгийн хуулийн үйлчлэлийн үед буюу 2012 оноос 2017 оны хагас жил хүртэлх 5 жил 6 сарын хугацаанд 254 хэргийг шийдвэрлэж байсан бол 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд буюу 6 жил 6 сарын хугацаанд 1084 хэргийг шийдвэрлэж 4.2 дахин буюу эрс нэмэгдсэн.

2.Хэрэглэгч болон шүүгдэгчийн хүйсийн ялгааг харьцуулахад, 2019 онд Донтолт судлалын клиникт хэвтэн эмчлүүлсэн 69 өвчтөний 77.5 хувь нь эрэгтэй байсан бол энэхүү судалгааны шүүхийн шийтгэх тогтоолд хийсэн дүн шинжилгээгээр 91.6 хувь нь эрэгтэй, 8.4 хувь нь эмэгтэй шүүгдэгч байсан бөгөөд эрэгтэйчүүдийн дунд хэрэглээ илүү.

Насны хувьд, 2019 онд 20-39 насныхан хамгийн их хувийг эзэлж байсан бол шүүхийн шийтгэх тогтоолд хийсэн дүн шинжилгээгээр 21-30 насныхан энэ төрлийн гэмт хэрэгт хамгийн их 227 шүүгдэгч буюу 63.9 хувийг эзэлж байгаа улам бүр залуужиж байгааг илэрхийлж байна. Энэ төрлийн гэмт хэргийг 21-30 настай залуучууд хамгийн их үйлддэг бөгөөд урьд 1-5 удаа эрүүгийн хариуцлага хүлээж байсан залуучууд, тэр дундаа 21-25 насныхан байгаа нь онцгой анхаарал татаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд хийсэн 2017 оны судалгааны үр дүн өсвөр насныхан болон залуучууд найз нөхдийн нөлөөнд автах, шохоорхох, интернэт орчин, кинонд гардаг үйлдлийг дуурайх, дууны үг болон клипээс санаа авах, түүнийгээ туршиж үзэх, улмаар олон дахин хэрэглэж зуршил болгон донтох хэлбэрээр бий болдог нь тогтоогдсон нь шүүхийн шийтгэх тогтоолд хийсэн дүн шинжилгээний үр дүнтэй адилхан гарсан.

3.Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд, гэмт хэргийн гаралт Улаанбаатар хотод хамгийн их буюу 337, орон нутагт 63 байна. Улаанбаатар хотын дүүргүүдээс Баянгол дүүрэгт хамгийн их буюу 22.8 хувь, орон нутгаас Орхон аймагт хамгийн их буюу 44.4, Дархан-Уул аймагт 23.8, Сэлэнгэ аймаг 15.8 хувийг тус тус эзэлж буйгаас үзэхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг нь төв суурин газар, хүн ам олноор төвлөрсөн нутаг дэвсгэрт түгээмэл гарсан.

4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын төрлийн хувьд шүүгдэгч нарын 403 буюу 77.6 хувь нь “өвс”, “шавар” гэх нэршилтэй “Дельта-9 тетрагидроканнабинол /delta 9 tetrahydrocannabinol/”-ын агууламжтай сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой, 88 буюу 16.9 хувийг “мөс” гэх нэршилтэй, метамфетамин агууламжтай сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бол эм болон тарианы төрлүүдтэй Морфин /Morphine/-ийг 10 буюу 1.9 хувь нь холбоотой.

5.Засгийн газраас 2017 онд хэрэгжүүлсэн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийн 3.3.9. дэх хэсэгт тусгасан “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант эмгэгтэй болон мансуурсан хүнд сайн дурын болон албадан эмчилгээ, сэтгэл зүйн тусламж үзүүлэх, нийгэмшүүлэх үйлчилгээний төв байгуулах” гэсэн заалт өнөөдрийг хүртэл биелэгдээгүй байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодист донтсон, түүнээс бүрэн хараат болсон хүнд ял шийтгэл оногдуулснаар энэ төрлийн гэмт хэрэг буурахгүй бөгөөд олон улсын жишиг төвийг байгуулж, эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлснээр гэмт хэргийн гаралтыг бууруулахад шууд нөлөөлдөг талаар гадаад орны туршлагаас харагдаж байна. Тодруулбал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнтэй аргуудын нэг нь далд хэрэглэгчийг ил гаргаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлснээр хар зах зээл дээрх хэрэглэгчийн тоог бууруулах улмаар борлуулагчийг ил болгоход чухал ач холбогдолтой тул дээрх хөтөлбөрийг шинэчлэн баталж хэрэгжүүлэх нь чухал байна гэжээ.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах асуудал, зохицуулагдах харилцаа, хамрах хүрээний талаар;

1.Мансууруулах эм гэдгийг Монгол улс 1990 онд нэгдэн орсон Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц (Convention on Narcotic drugs, UN 1961)⁵, сэтгэцэд нөлөөт бодис гэдгийг Монгол улс 1999 онд нэгдэн орсон Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенц (Convention on psychotropic substances, UN 1971)⁶ -д тус тус ялгамжтайгаар авч үзсэн.

⁵ <https://www.unodc.org/unodc/en/treaties/single-convention.html?ref=menuside>

⁶ <https://www.unodc.org/unodc/en/treaties/psychotropics.html?ref=menuside>

2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль ёсны эргэлтийг энэ хуульд зааснаар, хууль бус эргэлтийг Монгол улс 2001 онд нэгдэн орсон Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн тухай конвенц (Convention against Illicit traffick in narcotic drugs and psychotropic substances, UN 1988)-ийн үзэлд баримтлал, агуулгад бүрнээ нийцүүлсэн.

3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны чиг үүргийг илүү тодорхой болгож, хороог хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн удирдахаар, ажлын албаны чиг үүргийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба хэрэгжүүлэхээр тусгасан.

Энэ нь хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотой шинээр байгууллага бий болгохоос зайлсхийхийн зэрэгцээ хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд үйл ажиллагаа явуулж буй Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үндсэн чиг үүрэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг зохицуулах, хяналт тавих, тайлагнах чиг үүргийг нэгтгэснээр Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн зорилт, агуулгад нийцсэн.

Үндэсний хороо мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль ёсны болон хууль бус эргэлтийн төлөв байдлын тайланг, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналын хамт Засгийн газарт жил бүрийн 10 дугаар сард багтаан тайлагнаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд мэдээлж байхаар зохицууллаа.

4.Эрүүгийн хуульд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хууль бус эргэлттэй тэмцэх, гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогод шинэлэг өөрчлөлт тусгасан. Тухайлбал:

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт болох гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах, шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий цагдаа, тагнуул, авлигатай тэмцэх газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, гааль болон төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх бусад байгууллагын ажилтан, алба хаагч, мөрдөгч, прокурор, шүүгч энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн, хамтран оролцсон тохиолдолд тэдэнд оногдуулах ялыг 2 дахин нэмэгдүүлэхээр тусгасан.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

1.Судалгаагаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх аливаа сурталчилгаа нь мансууруулах бодисын хэрэглээний талаарх танилцуулга болдог сөрөг үр дагавартай болох нь батлагдсан тул Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хуулийн 11 дүгээр зүйлд заасан “төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, түүнчлэн эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл урлаг, шинжлэх ухаан, боловсролын байгууллага болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага сурталчилгаа явуулах үүрэгтэй” гэж заасан зохицуулалтаас үүрэгжүүлсэн заалтыг хасахаар;

2.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 9 төрлийн гэмт хэрэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг үйлдсэн, хамтран оролцсон төрийн албан хаагчдад оногдуулах ялыг 2 дахин нэмэгдүүлж оногдуулахаар тусгасан.

Энэ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5 дугаар бүлэгт заасан ерөнхий зохицуулалт, ялын төрөл, хэмжээний дээд хязгаараас хэтрэхгүй юм.

3.Засгийн газраас 2017 онд баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийн 3.3.9 дэх хэсэгт тусгасан “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант эмгэгтэй болон мансуурсан хүнд сайн дурын болон албадан эмчилгээ, сэтгэл зүйн тусламж үзүүлэх, нийгэмшүүлэх үйлчилгээний төв байгуулах” зорилтыг хуульд хэрэгжүүлэхээр тусгаж, Засгийн газар нь мансуурах донтой этгээдэд эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нийгэмшүүлэх үйлчилгээний журмыг боловсруулахаар, мөн мансуурах донтой хүн сайн дурын үндсэн дээр эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж авах, эмчилгээнд хамрагдах, нийгэмших талаар гаргасан аливаа санал санаачлагыг төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн сайн дурын бүлэг, иргэд бүхий л талаар дэмжихээр тусгасан. Олон нийтийн сайн дурын бүлэг гэдэгт шашны болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дэх иргэдийн нэгдэл, сайн дурын бүлгүүдийг авч үзсэн болно.

4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэж, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 3.1-д заасан “албадан эмчилгээ”-г, мөн хуулийн 17 дугаар зүйлд зааснаар “давтан” эмчлүүлснээс хойш нэг жилийн дотор дахин мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэсэн болох нь батлагдсан тохиолдлыг “гэмт хэрэг” гэж үзэх зохицуулалтыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20 дугаар бүлэгт томъёолж, нэмэлт өөрчлөлт оруулахаар;

5.Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих” гэсэн зөрчлийг, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль зөрчих” гэж өөрчлөн найруулахаар тус тус томъёолсон болно.